

**ГЭР БҮЛИЙН ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН
ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ,
ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

Хуулийн төсөл санаачлан

боловсруулагч:

Хууль зүй, дотоод хэргийн яам

Гүйцэтгэгчийн нэр:

Г.Сувд-Эрдэнэ

АГУУЛГА

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

НЭГ.ХУУЛИЙН ТӨСӨЛД ҮНЭЛГЭЭ ХИЙХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ
СОНГОХ:

- 1.1.Зорилгод хүрэх байдал;
- 1.2.Ойлгомжтой байдал;
- 1.3.Харилцан уялдаа.

ХОЁР.ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ НЬ ҮНЭЛЭХ ХЭСГЭЭ ТОГТООХ:

- 2.1."Практикт хэрэгжих боломж" шалгуур үзүүлэлтийн хүрээнд;
- 2.2."Ойлгомжтой байдал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд;
- 2.3."Харилцан уялдаа" шалгуур үзүүлэлтийн хүрээнд

ГУРАВ.ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ:

- 3.1."Практикт хэрэгжих боломж" шалгуур үзүүлэлтийн хүрээнд;
- 3.2."Ойлгомжтой байдал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд;
- 3.3."Харилцан уялдаа" шалгуур үзүүлэлтийн хүрээнд;

ДӨРӨВ.ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН
БАЙДАЛ:

- 4.1.Үр дүнг баримтжуулах;
- 4.2.Үнэлт, дүгнэлт;
- 4.3.Зөвлөмж өгөх.

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ.

ГЭР БҮЛИЙН ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

НЭГ.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Монгол Улсын Их Хурлаас 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр баталсан Шүүх байгуулах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-иар Нийслэл дэх Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан шатны тойргийн шүүх, улсын хэмжээнд Гэр бүл, хүүхдийн хэргийн давж заалдах шатны шүүхийг тус тус байгуулахаар хуульчилжээ.¹

Ийнхүү дагнан байгуулсан дээрх Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхийн үйл ажиллагаатай холбоотой зохицуулалт 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр заасан.² байх бөгөөд үүнтэй холбогдуулан “Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 68 дугаар тогтоолын 4-т нийслэлд Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан шатны тойргийн болон давж заалдах шатны шүүх байгуулсантай холбогдуулан эрүү, иргэний хэргийг хянан шийдвэрлэх хууль тогтоомжид холбогдох зохицуулалтыг тусган Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд өргөн мэдүүлэхийг Засгийн газарт даалгасан байна.

Түүнчлэн Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Монгол Улсын шүүхийн тухай хуульд заасны дагуу Улсын дээд шүүхтэй зөвшилцөн баталсан “Улсын дээд шүүхээс бусад шүүхийг байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах, түүний байршлыг тогтоох асуудлыг боловсруулахад харгалзан үзэх шалгуур үзүүлэлт”-д үндэслэн шүүх байгуулах асуудлыг боловсруулахад харгалзан үзэх нийт 3 төрлийн багц судалгааг хөндлөнгийн байгууллагатай хамтран хийсэн байна.

Уг судалгаа нь шүүхийн шүүн таслах ажиллагааны статистик тоо, шүүхийн захиргааны тайлан, мэдээлэл болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ачаалалд хийсэн ажлын байрны ажиглалт, асуумж, хэрэг уншилтын судалгаанд тус тус үндэслэсэн бөгөөд дүнг багцалбал “...одоогийн шүүхийн зохион байгуулалт нь шүүх, шүүгчийн хэргийн болон ажлын ачаалал тэнцвэргүй, зарим шүүхийн шийдвэрлэж байгаа хэрэг, маргааны төрөл, тоо хэт бага байгаа нь шүүгч мэргэших боломжгүй байх нөхцөлийг бүрдүүлсэн, **шүүн таслах ажлын төрлөөр дагнаж төрөлжсөн шүүх байгуулах**, шүүгчийн орон тоог ачаалалд уялдуулан өөрчлөх хэрэгцээ шаардлага үүссэн.” гэж дүгнэжээ.

Мөн Шүүхийн ерөнхий зөвлөлөөс 2019 онд “Хууль эрх зүйн хөгжлийн хүрээлэн” ТББ-аар хэргийн дагнан шийдвэрлэх “Улаанбаатар хотод гэр бүл, өсвөр насны хүний хэргийн шүүх, танхим байгуулах” тухай тандан судалгаа хийлгэсэн бөгөөд судалгаагаар “...**гэр бүлийн дагнасан шүүх байгуулах хэрэгцээ, шаардлага үүссэн**” гэсэн дүгнэлтэд хүрсэн байна.

Ийнхүү дээр дурдсан Шүүх байгуулах тухай хуулиар байгуулсан Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх онцлог ажиллагааг зохицуулсан процессийн хуулийн төслийг

¹ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17140721145671>

² <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17140721217671>

боловсруулах, ингэхдээ хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ³, бусад улсын харьцуулсан судалгаа⁴ зэрэгт үндэслэн хэрэгцээ, шаардлагыг тодорхойлж, түүнд нийцүүлэн Хууль зүй, дотоод хэргийн яамнаас боловсруулж, 2025 оны 05 дугаар сарын 12-ны өдөр олон нийтээс санал авахаар тус яамны цахим хуудсанд байршуулсан Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөлд /цаашид “Хуулийн төсөл” гэх/ үр нөлөөний үнэлгээг хийв.

Хуулийн төсөл нь 6 бүлэг, 35 зүйлтэй.

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэхдээ Хууль тогтоомжийн тухай хуулийн⁵, 17 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал⁶”/цаашид “аргачлал” гэх/-ыг баримтлан хийлээ.

³ Гэр бүл, хүүхдийн холбогдолтой хэргийг шүүхээс хянан шийдвэрлэх ажиллагааны талаарх хууль тогтоомжид хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийсэн тайлан 2024 он.

⁴ Гэр бүл, хүүхдийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны хууль тогтоомжийн харьцуулсан судалгаа.

⁵ УИХ-аас 2015 оны 5 дугаар сарын 29-ний өдөр баталсан.

⁶ Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.1-д заасны дагуу Монгол Улсын Засгийн газраас 2016 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан.

НЭГ.ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ

Хуулийн төслийн үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан аргачлалд дурдсан дараахь 3 шалгуур үзүүлэлтийг сонголоо. Үүнд:

- 1.Зорилгод хүрэх байдал
- 3.Ойлгомжтой байдал
- 4.Харилцан уялдаа.

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, хэрэгцээ шаардлагад хуулийн төслийн зорилго, зохицуулалтууд нь нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх үүднээс хуулийн төслийн үзэл баримтлалтай танилцаж, үзэл баримтлал болон хуулийн төслийн зорилго, түүнийг хангахад чиглэсэн зохицуулалтыг харьцуулж дүн шинжилгээ хийхээр сонгов.

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийг хуулийн төсөл нь түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдүүдийн хувьд ойлгомжтой, логик дараалалтай томъёологдсон эсэх, хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгах зорилгоор сонголоо.

“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийг хуулийн төсөл нь өөр хоорондоо болон бусад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуультай уялдах уялдаа холбоог сайжруулах үүднээс хуулийн төслийн зүйл, хэсэг, заалт өөр хоорондоо болон хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад хуульд нийцсэн эсэх, давхардал, хийдэл, зөрчил байгаа эсэхийг тогтоох зорилгоор аргачлалд заасан асуултад хариулах замаар шалгахаар сонгов.

ХОЁР.ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ

“Зорилгод хүрэх байдал” Хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төсөл боловсруулах болсон хэрэгцээ, шаардлагад нийцсэн эсэхийг шалгахын тулд хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хэрэгцээ шаардлагыг хуулийн төсөлд хэрхэн тусгасныг тогтоох, эдгээр зохицуулалт нь үзэл баримтлалд тодорхойлсон хэрэгцээ, шаардлагад бүрэн нийцсэн эсэхийг харьцуулан дүгнэхээр үнэлэх хэсгээ тогтоолоо.

Хуулийн төсөлд одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн Арванхоёрдугаар бүлэгт заасан гэр бүлийн холбогдолтой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, мөн хуулийн Арвангуравдугаар бүлгийн 133 дугаар зүйлийн 133.1.2-133.1.7 дахь хэсэгт заасан онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэх хэргүүд, 135 дугаар зүйлийн 135.2.1-135.2.13 дахь хэсэг, 137-150 дугаар зүйлд тус тус заасан эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдлыг хянан шийдвэрлэхтэй холбоотой зохицуулалтыг дагнасан шүүх байгуулсантай холбогдуулан тусгасан байх тул Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай

хуулиар зохицуулаагүй буюу энэхүү хуулийн төсөлд хуульчлахаар тусгасан шинэ зохицуулалтыг сонгож зорилгод хүрэх байдлыг тодорхойлохыг зорьсон.

Зорилгод хүрэх байдал <i>/Хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хэрэгцээ, шаардлага/</i>	Үр нөлөөг тооцох хэсэг <i>/Сонгосон зүйл заалт/</i>
1.Нийтийн болон хувийн эрх зүйн маргаан шийдвэрлэх ажиллагааны зарчим ялгаатай хэдий ч гэр бүлийн холбогдолтой хэрэгт диспозитив зарчмаас гадна хүүхдийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах үүднээс шүүхээс хянан шалгах, нотлох баримт цуглуулах үүрэг бусад улсуудад байгааг харгалзан үзэх шаардлага үүссэн.	Хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэг; 12 дугаар зүйл.
2.Гэр бүлийн хэргийн талаар зөвхөн талууд бус сонирхогч тал нэхэмжлэл гаргах боломжийг хуульчлах шаардлага үүсэж байна.	Хуулийн төслийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь
3.Гэрлэлт цуцлалтын хэргийг шүүхээс шийдвэрлэхэд хүүхэдтэй холбоотой бусад асуудлыг заавал хамтад нь шийдвэрлэж, гэрлэлт цуцлалтаас үүдэж хүүхдийн эрх, ашиг сонирхол зөрчигдөхөөс сэргийлэх шаардлага үүссэн.	Хуулийн төслийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэг, 10.3 дахь хэсэг, 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэг, 15 дугаар зүйлийн 15.4 дэх хэсэг, 17.2 дахь хэсэг, 17.3 дахь хэсэг
4.Шүүх дэх эвлэрүүлэн зуучлалаар гэрлэгчид шууд утгаар эвлэрэхээс гадна гэрлэлт цуцлалттай холбоотой бусад асуудал болох хүүхдийн асрамж, уулзах цаг, хүүхдийн тэтгэлэг, эд хөрөнгө хуваах асуудлыг тохиролцох боломжтой байдлаар тусгах шаардлага үүссэн.	Хуулийн төслийн 33 дугаар зүйл.
5.Гэр бүлийн холбогдолтой хэргийг шүүхээс шийдвэрлэхэд хүүхдийн эмзэг байдлыг харгалзаж, хүүхдийн сэтгэл зүйч оролцох, хүүхдэд шүүхээс асуулт тавихдаа хүүхдийн сэтгэл зүйчээр дамжуулан асуух зэрэг шаардлага үүссэн.	Хуулийн төслийн 19 дүгээр зүйл

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийг хуулийн төслийг хэрэгжүүлэх, хэрэглэх субъектүүдэд ойлгомжтой тодорхой байх, хуулийн төслийн бичвэр нь нэр томъёо, хэл зүй, найруулгын хувьд Хууль тогтоомжийн тухай хуулийн холбогдох заалтууд, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”-д заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгах үүднээс бүхэлд нь үнэлэхийг зорьж сонголоо. /Хуулийн төсөл нь 6 бүлэг, 35 зүйлтэй./

“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд аргачлалд тусгасан хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх стандарт асуултуудад хариулах замаар уялдаа

холбоог шалгах үүднээс хуулийн төслийг бүхэлд нь авч үзэхээр тооцлоо. /Хуулийн төсөл нь 6 бүлэг, 35 зүйлтэй./

ГУРАВ.ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Аргачлалд заасны дагуу хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлт, үр нөлөөг үнэлэх хэсгийг дээрх 2 үе шатанд тус тус тогтоосны дагуу тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг дараахь байдлаар тодорхойллоо:

Д/д	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Тохирох шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслийн 4 дүгээр 4.1 дэх хэсэг; 12 дугаар зүйл, 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэг, 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэг, 10.3 дахь хэсэг, 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэг, 15 дугаар зүйлийн 15.4 дэх хэсэг. 17.2 дахь хэсэг, 17.3 дахь хэсэг, 33 дугаар зүйл, 19 дүгээр зүйл	Зорилгод дүн шинжилгээ хийх: Хуулийн төслийн зохицуулалт нь төслийн үзэл баримтлалд дурдсан хэрэгцээ, шаардлагад нийцсэн эсэхэд дүн шинжилгээ хийнэ.
2	Ойлгомжтой байдал	Хуулийн төсөл бүхэлдээ	Ойлгомжтой байдлыг шалгах: Хуулийн төсөлд хамаарах этгээдүүдээс уг төсөл нь ойлгомжтой байдлаар томъёологдсон эсэхийг шалгах, түүнчлэн Хууль тогтоомжийн тухай хууль, “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”-ыг баримталсан эсэхийг шалгана.
3	Харилцан уялдаа	Хуулийн төсөл бүхэлдээ	Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах: Хуулийн төслийн уялдаа холбоог аргачлалын 4.10-т заасан асуултад хариулах замаар шалгана.

Дээр дурдсан урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлт, шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг дараах байдлаар хийв:

3.1.“Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төсөл боловсруулах болсон хэрэгцээ, шаардлагад нийцсэн эсэхийг шалгахын тулд

хуулийн төслийн үзэл баримтлалд⁷ тусгасан хэрэгцээ шаардлагыг хуулийн төсөлд хэрхэн тусгасныг тогтоох, эдгээр зохицуулалт нь үзэл баримтлалд тодорхойлсон хэрэгцээ, шаардлагад нийцэж байгаа эсэхийг харьцуулан дүн шинжилгээ хийлээ.

Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан болон давж заалдах шатны шүүх байгуулсан хууль санаачлагчийн үзэл баримтлал, танилцуулгыг сөхөхөд:

“Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан болон давж заалдах шатны шүүх байгуулах зорилго нь гэр бүл, насанд хүрээгүй хүний хэргийг харьяалан шийдвэрлэх шүүхийн мэргэшсэн тогтолцоо бүрдүүлэх замаар гэр бүл, хүүхдийн эрх ашгийг хамгаалах, төрөөс баримтлах гэр бүл, хүүхэд хамгааллын бодлогыг үр ашигтай, бодитой хэрэгжүүлэх, гэр бүл, хүүхэд хамгааллын холбогдох байгууллагуудыг бэхжүүлэх юм.

Гэмт хэрэг, зөрчил үйлдсэн, өөр бусад байдлаар шүүх үйл ажиллагаанд татагдан оролцож буй насанд хүрээгүй хүмүүсийн хувьд тэдний нас, бие, сэтгэл зүйн онцлогт тохирсон, цаашид бие хүн болон төлөвшихөд нь онцгой анхаарсан хэрэг хянан шийдвэрлэх эерэг орчин, тусгай журам шаардагддагийг дэлхий нийт анхааран хүүхдийн хэргийн шүүх, гэр бүлийн шүүхийг дагнан байгуулж байна.

Монгол Улсад ч мөн адил гэр бүл, насанд хүрээгүй хүний дагнасан шүүх байгуулах хэрэгцээ, шаардлага үүссэн талаар холбогдох судалгаа гарсан бөгөөд ийнхүү үүссэн хэрэгцээ, шаардлага, гэр бүлийн хэрэг, маргаан болон гэмт хэрэг, зөрчил үйлдсэн насанд хүрээгүй хүний статистик тоон мэдээлэл, хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр Монгол Улсын олон улсын гэрээ конвенцоор хүлээсэн үүрэг, бусад улсын жишиг, чиг хандлага зэргийг харгалзан тэдгээрийн онцлогт тохирсон гэр бүл, насанд хүрээгүй хүний хэргийг харьяалан шийдвэрлэх шүүхийн мэргэшсэн тогтолцоо бүрдүүлэх үүднээс Гэр бүл, хүүхдийн хэргийн дагнасан шүүх байгуулах” зорилгыг тодорхойлжээ.

Ийнхүү хэрэгцээ, шаардлагыг тодорхойлсны үндсэн дээр Монгол Улсын Их Хурлаас 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр баталсан Шүүх байгуулах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-иар Нийслэл дэх Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан шатны тойргийн шүүх, улсын хэмжээнд Гэр бүл, хүүхдийн хэргийн давж заалдах шатны шүүхийг тус тус байгуулахаар хуульчилжээ.

Эндээс үзэхэд, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын дүүргүүдийн хэмжээнд эзэлж буй гэр бүлийн хэрэг, маргаан, тухайлбал, хүн амын суурьшил, төвлөрөлтэй холбоотойгоор улсын хэмжээнд хянан шийдвэрлэсэн нийт гэр бүлийн хэрэг, маргааны 50 орчим хувь нь нийслэл Улаанбаатар хотын төвийн 6 дүүргийн шүүхээр хянан шийдвэрлэгдсэн талаарх болон насанд хүрээгүй хүний үйлдсэн гэмт хэргийн гаралт, маргааны тоо, ажлын ачааллын талаарх тоон мэдээлэл, статистик зэрэгт үндэслэн нийслэлийн 6 дүүргийн хүрээнд Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан шатны шүүхийг байгуулсан байна.

Харин орон нутагт гарч байгаа хэрэг, маргааны тоо, төрлийг харгалзан энэ төрлийн хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх дагнасан шүүхийг тусад нь байгуулах шаардлагагүй гэж үзэн үүнийг Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3 дахь хэсэгт зааснаар орон нутаг дахь анхан шатны шүүх шүүн таслах ажиллагааны төрлөөр дагнасан танхим байгуулах, эсхүл тухайн шатны шүүхийн

⁷Хууль зүй, дотоод хэргийн сайдын баталсан Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийн үзэл баримтлал

шүүгчийг энэ чиглэлээр мэргэшүүлэх зэрэг дэлхийн улсад байдаг дагнасан шүүхийн бусад загвар, хэлбэрээс сонгон хэрэгжүүлэх асуудлыг орон нутгийн шүүхэд нээлттэй үлдээсэн байна гэж үзэв.

Түүнчлэн ийнхүү орон нутаг дахь анхан шатны шүүхийн шийдвэрлэсэн хэргийг давж заалдах журмаар Гэр бүл, хүүхдийн хэргийн давж заалдах шатны дагнасан шүүх шийдвэрлэх нь өөрөө энэ чиглэлээрх мэргэшсэн шүүхийн тогтолцоо бүрдэх нэг хэсэг гэж үзэж байна.

Хууль эрх зүйн хөгжлийн хүрээлэнгээс Нээлттэй Нийгэм Форумын дэмжлэгтэйгээр хийсэн “Шүүхийн тогтолцоо: Тойргийн болон дагнасан шүүх” бодлогын судалгаанд:

“Дагнасан шүүх байгуулахад (i) эрх зүйн тусгай мэдлэг шаардсан хэрэг маргаан байгаа эсэх; (ii) ердийн шүүхээс гадна нэмэлт, тусдаа процесс шаардлагатай эсэх; (iii) гарч буй хэрэг маргааны тоо, ирээдүйн төлөв байдал; (iv) дагнасан шүүх байгуулах бусад хүчин зүйл буюу дотоод хэрэгцээ шаардлага гэсэн үндсэн голлох хүчин зүйлийг харгалзан үзэх шаардлагатай.

Түүнчлэн шүүхийг дагнан байгуулах шаардлагад шүүхийн нэмэлт үйлчилгээ болон хэрэг маргаан хянан шийдвэрлэх тусдаа процессын хууль шаардлагатай эсэхийг харгалзан үзэж, энэ 2 хэрэгцээ, шаардлага байвал дагнуулах шийдлийг сонгодог байна. Тухайлбал, дагнасан шүүхийн зорилго болоод хэрэг маргааныг шийдвэрлэх процесс өөрийн онцлогтой. Жишээ нь гэр бүлийн болон насанд хүрээгүй хүний шүүх нь илүү уян хатан, талуудыг эвлэрүүлэхэд чиглэсэн процессийн хуультай байдаг.

Дагнасан шүүх байгуулах хэрэгцээ шаардлагад нэн чухал хүчин зүйл бол хэргийн гаралт, маргааны тоо, тухайн маргааныг шийдвэрлэх тусдаа процессийн хууль шаардлагатай хэрэг маргаан, мөн шүүхийн нэмэлт үйлчилгээ үзүүлэх дэд бүтэц зайлшгүй шаардлагатай бол дагнасан шүүх байгуулж байна.

Энэ шалгуураар авч үзвэл манай улсад гэр бүл, насанд хүрээгүй хүний хэрэг шийдвэрлэх дагнасан шүүх байгуулж болох юм. Гэр бүлийн шүүхийг насанд хүрээгүй хүний үйлдсэн гэмт хэргийг хамтад нь шийддэг байхаар байгуулах, ингэхдээ энэ төрлийн шүүхийн хэрэг маргаан хянан шийдвэрлэх процессийн хуулийн онцлогийг судалж, хуулийг батлах нь бодлогын зөв шийдэл болно.” гэжээ.

Иймд Монгол Улсын Их Хурлаас 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр баталсан Шүүх байгуулах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-иар Нийслэл дэх Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан шатны тойргийн шүүх, улсын хэмжээнд Гэр бүл, хүүхдийн хэргийн давж заалдах шатны шүүхийг тус тус байгуулсан зохицуулалт 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжих гэж байгаатай холбогдуулан Гэр бүлийн холбогдолтой хэргийг шүүхээс хянан шийдвэрлэх ажиллагааны талаарх хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, Гэр бүл, хүүхдийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хууль тогтоомжийн бусад улсын харьцуулсан судалгаа зэрэгт үндэслэн хэрэг хянан шийдвэрлэх онцлог ажиллагааг зохицуулсан процессийн хуулийн төслийг боловсруулах хэрэгцээ, шаардлагыг илэрхийлсэн үзэл баримтлалыг тодорхойлж, түүнд нийцүүлэн хуулийн төслийг боловсруулсан нь зарчмын хувьд үзэл баримтлалд тодорхойлсон хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна гэж үзлээ.

Ингэхдээ гэр бүлийн холбогдолтой иргэний хэргийг шүүх хянан шийдвэрлэхтэй холбогдсон онцлог харилцааг Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай, өсвөр насны хүн холбогдсон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхтэй холбоотой онцлог

харилцаа, уг хэргийг хянан шийдвэрлэх шүүхийн харьяалал зэрэг онцлог харилцааг Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан байна.

Дагалдуулан боловсруулсан зарим хуулийн төслийн зорилгод хүрэх байдлын тухайд:

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн **өсвөр насны хүн гэснийг** Гэр бүл, хүүхдийн хэргийн шүүхэд харьяалуулах шаардлагатай эсэхийг дахин нягтлах нь зүйтэй гэж үзэж байна.

Учир нь Шүүх байгуулах тухай хууль баталсантай холбогдуулан Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд оруулсан өөрчлөлтөөр Зөрчлийн тухай хуульд заасан эрүүгийн хэргийн шүүхийн анхан шатны журмаар харьяалан шийдвэрлэх зөрчлийн хэргийг нийслэлд Дүүргийн Эрүү, Иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатны тойргийн шүүх харьяалан шийдвэрлэж байна. Нөгөөтэйгүүр Зөрчлийн тухай хуульд зааснаар зөрчлийн шийтгэл хүлээх хүн 16 насанд хүрсэн байхаар заасан, Зөрчлийн тухай хуульд өсвөр нас гэсэн нэр томьёо байхгүй зэрэгтэй холбогдуулан зөрчил үйлдсэн өсвөр насны хүний хэргийг нийслэлд Дүүргийн Эрүү, Иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатны тойргийн шүүхээс дахин салгаж Гэр бүл, хүүхдийн хэргийн шүүхэд харьяалуулах нь оновчтой эсэхийг дахин сайтар нягтлах нь зүйтэй гэж үзэж байна.

Түүнчлэн Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд зөрчлийн хэргийг Улсын дээд шүүх хяналтын журмаар хянан шийдвэрлэдэггүй тул Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтыг хуульд нийцүүлэн хасах нь зүйтэй.

1."Нийтийн болон хувийн эрх зүйн маргаан шийдвэрлэх ажиллагааны зарчим ялгаатай хэдий ч гэр бүлийн холбогдолтой хэрэгт диспозитив зарчмаас гадна хүүхдийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах үүднээс шүүхээс хянан шалгах, нотлох баримт цуглуулах үүрэг бусад улсуудад байгааг харгалзан үзэх шаардлага үүссэн" гэсэн хэрэгцээ шаардлагын хүрээнд:

Дээрх хэрэгцээ, шаардлагыг хангах агуулга бүхий зохицуулалтыг хуулийн төсөлд дараах байдлаар тусгажээ.

-4 дүгээр зүйл.Хуулийн зарчим 4.1.Энэ хуульд өөрөөр заагаагүй бол гэр бүлийн холбогдолтой хэргийг хянан шийдвэрлэхэд мэтгэлцэх зарчим болон шүүхээс мөрдөн шалгах ажиллагаа явуулах, хүүхдийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг тэргүүн ээлжид хамгаалах зарчим үйлчилнэ.

-12 дугаар зүйл.Гэрлэлт цуцлах тухай хэрэг хянан шийдвэрлэх

12.1.Шүүгч хэргийг хянан шийдвэрлэхдээ гэрлэлт цуцлах болсон шалтгааныг тогтоож, хүүхдийн асрамжийг шийдвэрлэх үүднээс гэрлэгчид хүүхэдтэй бол гэр бүлийн мөрдөн шалгах ажиллагааг шүүх санаачилгаар явуулах бөгөөд нэхэмжлэлийг хангавал гэрлэлт цуцлах тухай шийдвэр гаргана.

12.4.Энэ хуулийн 12.1-д заасан гэр бүлийн мөрдөн шалгах ажиллагааг Хүүхэд хамгааллын тухай хуулийн 18 дугаар зүйлд заасан нөхцөл байдлын үнэлгээ хийлгэхийг даалгасан захирамжийг шүүгч гаргаж, хүүхэд, гэр бүлийн

нийгмийн ажилтан, шаардлагатай тохиолдолд энэхүү үнэлгээг хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйчийг оролцуулсан багаар гүйцэтгүүлнэ.

12.5.Хүүхдийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах үүднээс шүүх шаардлагатай гэж үзвэл цагдаагийн байгууллага, захиргааны байгууллага болон банк, сургууль гэх мэт холбогдох бусад байгууллага, эсхүл хувь хүнээс гэрлэгчдийн дансны мэдээлэл, хөрөнгийн байдал, орлого, боловсролын байдал болон бусад шаардлагатай мэдээллийг нягтлан шалгаж болно.

Гэр бүл, хүүхдийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны хууль тогтоомжийн харьцуулсан судалгаа болон хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, үзэл баримтлалаар тодорхойлсон хэрэгцээ, шаардлагаас үзэхэд “Гэр бүлийн шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулахдаа мэргэжлийн байгууллагын дүгнэлт гаргуулах, лавлагаа, мэдээлэл гаргуулах, шаардлагатай гэж үзвэл гэр бүлийн орчин, нөхцөл байдлын талаар судлах, шалгах ажиллагааг шүүхийн ажилтны тусламжтайгаар хэрэгжүүлэх хүртэл арга хэмжээг авч болдог байна. Энэхүү тогтолцоо нь Гэр бүлийн шүүхэд байх өвөрмөгц тогтолцоо байх бөгөөд гэр бүлийн шүүх хэрэг маргааныг шийдвэрлэхийн тулд илүү мэргэжлийн байгууллагын оролцоог хангахаас гадна гэр бүлийн орчин нөхцлийг бодиттой судлан түүнд үнэлэлт дүгнэлт өгөх байдлаар шийдвэрлэхийг эрмэлзэх нь гэр бүлийн хэрэг маргааныг онцлогыг харгалзах зайлшгүй шаардлагатай байгааг илэрхийлж байна гэж дүгнэж болох юм.” гэжээ.

Ийнхүү үзэл баримтлалд шүүх гэр бүлийн холбогдолтой хэргийг хянан шийдвэрлэх үндэслэл болон гэр бүлийн талаар бодит байдал, нөхцөл байдлыг тогтоох, хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад зарим шаардлагатай шалгах ажиллагааг хийх, нэмэлт нотлох баримт цуглуулах хэрэгцээ шаардлагыг тодорхойлсны дагуу хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн зарчим, Гэрлэлт цуцлах тухай хэрэг хянан шийдвэрлэх талаарх 12 дугаар зүйлд тусгалаа олсон нь зарчмын хувьд үзэл баримтлалд тусгасан зорилго, хэрэгцээ шаардлагад нийцсэн, олон улсын чиг хандлагад нийцсэн, дэвшилтэт зохицуулалт байх бөгөөд үзэл баримтлалд тусгасан хэрэгцээ шаардлага буюу зорилгодоо нийцэж байна гэж үзэв.

Харин нэр томъёоны хувьд “**мөрдөн шалгах ажиллагаа**” гэж нэрлэсэн нь оновчгүй, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд “мөрдөн шалгах ажиллагаа” гэсэн нэр томъёог тодорхойлсон байгааг анхаарч, гэр бүлийн холбогдолтой иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд илүү нийцүүлэн оновчтой нэршлээр тодорхойлоход анхаарах нь зүйтэй байна. Тухайлбал, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд Шүүх нотлох зарчим гэж заасныг анхаарах.

Түүнчлэн хуулийн төслийн 4 дүгээр зүйлд тусгасан мөрдөн шалгах ажиллагаа явуулах зарчмыг хэрэгжүүлэх процессийг илүү тодорхой болгож төсөлд тусгах нь үзэл баримтлалд тусгасан зорилгыг бүрэн хангахаар байна гэж үзэв.

2.Гэр бүлийн хэргийн талаар зөвхөн талууд бус сонирхогч тал нэхэмжлэл гаргах боломжийг хуульчлах шаардлагын хүрээнд:

6.2.Сонирхогч тал гэр бүлийн холбогдолтой дараах нэхэмжлэлийг шүүхэд гаргана:

6.2.1.хүүхэд үрчлэх, хүүхэд үрчилснийг хүчингүйд тооцох;

6.2.2.асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр тогтоох болон асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр тогтоосныг хүчингүйд тооцох, учирсан хохирлыг нөхөн төлүүлэх;

6.2.3.эцэг, эх байх эрхийг хязгаарлах, хасах, эсхүл сэргээх;

6.2.4.гэрлэлтийг хүчин төгөлдөр бус, гэрлэлт цуцлалтыг хүчин төгөлдөр бус гэж тооцох;

6.2.5.гэрлэлт цуцлалтыг хүчин төгөлдөр бус гэж тооцсоноос бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх.

Үзэл баримтлалд “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2-т зааснаар нэхэмжлэгч гэж хуульд заасан эрх, эрх чөлөө, хуулиар хамгаалагдсан ашиг сонирхол нь зөрчигдсөн гэж үзэж эрхээ сэргээлгэхээр өөрийн болон бусдын нэрийн өмнөөс нэхэмжлэл гаргагч этгээдийг хэлэх бөгөөд гэр бүлийн холбогдолтой хэрэгт зөвхөн хуульд заасан эрх, эрх чөлөө, хуулиар хамгаалагдсан ашиг сонирхол нь зөрчигдсөн гэж үзэж эрхээ сэргээлгэхээр өөрийн болон бусдын нэрийн өмнөөс нэхэмжлэл гаргагч л нэхэмжлэл гаргаж болно.

Бусад улсын туршлагаас үзвэл, БНСУ, Япон Улсын хувьд, гэрлэлт цуцлалтыг хүчингүйд тооцох, гэрлэлтийг хүчин төгөлдөр бусад тооцох, гэр бүлийн дундын эд хөрөнгийг хуваах, гэрлэлттэй адилтгах харилцаанд гэр бүлийн дундын эд хөрөнгө хуваахтай адил зарчмаар хуваах, үрчлүүлэх, үрчлэлтийг хүчингүйд тооцох, асран хамгаалагчийг томилох, эцэг эх байх эрхийг хасах, хязгаарлах, сэргээх, тэжээн тэтгэх, тэтгэлгийн хэмжээг өөрчлөх, хүүхдийн хуваарьт хөрөнгийг зориулалтын бусаар ашиглах зэргийг гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх тухай бие даасан хуулиараа зохицуулж байна.

Мөн эдгээр төрлийн нэхэмжлэлүүдэд гэрлэгчид төдийгүй, хүүхэд, төрөл садангийн хүн, прокурор, орон нутгийн байгууллага зэрэг сонирхогч этгээд нэхэмжлэл гаргах эрхтэй буюу гуравдагч этгээдийн нэхэмжлэл гаргах эрх, түүнчлэн шүүх өөрийн санаачилгаар авч болох арга хэмжээ, тухайлбал мөрдөн шалгах, бусад этгээдээс баримт, нотолгоо шаардах зэргийг тусгажээ.

Сонирхогч талын нэхэмжлэх эрхийг бий болгосноор тухайн маргааны улмаас хүүхдийн эрх, ашиг сонирхол зөрчигдсөн байдлыг цаг алдалгүй мэдэгдэх ач холбогдолтой зохицуулалт байдаг тул энэ талаарх зохицуулалтыг холбогдох нэхэмжлэлийн төрөлд бий болгох шаардлагатай байна.” гэжээ.

Үзэл баримтлалд тусгасан сонирхогч талын нэхэмжлэх эрхийг бий болгох эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор хуулийн төслийн дээрх 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэгт сонирхогч тал гэр бүлийн холбогдолтой ямар асуудлаар нэхэмжлэл гаргах зохицуулалт, үүнтэй уялдуулан хуулийн төслийн 15 дугаар зүйл, 16 дугаар зүйл, 17 дугаар зүйлд энэ талаар тусгасан нь үзэл баримтлалд тусгасан хэрэгцээ, шаардлагыг хангасан байна гэж үзлээ.

Харин “сонирхогч тал” гэсэн нэр томъёотой холбоотой дараах асуудлыг анхаарах шаардлагатай байна гэж үзэв. Үүнд:

1/”Сонирхогч тал” гэсэн нэр томъёо одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Гэр бүлийн тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд байхгүй бөгөөд харин Хууль зүй, дотоод хэргийн яамнаас боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтсон Гэр бүлийн

тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.13-т “сонирхогч тал” гэж 14 насанд хүрсэн хүүхэд өөрөө, эсхүл хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, бусад гэр бүлийн гишүүн, төрөл, садан, эсхүл хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах байгууллага, албан тушаалтан, эсхүл эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдсөн, зөрчигдсөн этгээдийг,” гэж тодорхойлсон байна.

Иймд Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл энэхүү процессийн хуулийн төсөлтэй хамтад нь хэлэлцэх тохиолдолд уг хуулийн төслөөс энэхүү хуулийн төсөлд “сонирхогч тал” гэж томъёолсон нэр томъёог эшлэх байдлаар тусгах, эсхүл шаардлагатай тохиолдолд энэхүү хуулийн төсөлд нэр томъёоны тодорхойлолт байдлаар тусгах;

2/Хуулийн төслийн 25 дугаар зүйлийн 25.1-д “Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис, согтууруулах ундаа байнга хэрэглэдгийн улмаас иргэний эрх зүйн чадамжийг хязгаарлуулах тухай сэтгэцийн өвчний улмаас иргэний эрх зүйн чадамжгүй гэж тооцуулах тухай хүсэлтийг уг иргэний гэр бүлийн гишүүн, эсхүл **сонирхогч бусад этгээд** /сонгуулийн хороо, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Засаг дарга/, асран хамгаалах байгууллага, эрүүл мэндийн байгууллага шүүхэд гаргана.” гэжээ.

Энэ “сонирхогч бусад этгээд” гэдэг нь энэхүү хуулийн төсөл болон Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.13-т тусгасан “сонирхогч тал” гэсэн нэр томъёо мөн эсэхийг нягталж, мөн бол эдгээр хуулийн төсөлд тусгасан нэг нэршлээр жигдлэх.

3.Гэрлэлт цуцлалтын хэргийг шүүхээс шийдвэрлэхэд хүүхэдтэй холбоотой бусад асуудлыг заавал хамтад нь шийдвэрлэж, гэрлэлт цуцлалтаас үүдэж хүүхдийн эрх, ашиг сонирхол зөрчигдөхөөс сэргийлэх шаардлагын хүрээнд:

10.2.Асрамж тогтоох, тэжээн тэтгэх болон эд хөрөнгийн талаарх хүсэлтийг нэхэмжлэлийг энэ хуулийн 10.1-д заасан гэрлэлт цуцлах нэхэмжлэлтэй хамт шүүх шийдвэрлэнэ.

10.3.Нэхэмжлэгчийн хүсэлтээр гэрлэлт цуцлалттай холбоотой гэм хор учруулсны нөхөн төлбөр төлүүлэх нэхэмжлэлийг энэ хуулийн 10.1-д заасан нэхэмжлэлтэй хамт шийдвэрлэж болно

12.2.Шүүгч гэрлэлт цуцлах тухай шийдвэр гаргахдаа хүүхдийг цаашид хүмүүжүүлэх талаар гэрлэгчдийн хооронд хэлэлцэн тохирсон зүйл байхгүй бол хүүхдийг эцэг буюу эхийн хэний нь асрамжид үлдээх, уулзах цаг, хамтран өмчлөх дундын өмчийг хуваах, хүүхдийн тэтгэлэг гаргуулах болон орон сууцны маргааны асуудлыг хянан шийдвэрлэнэ.

15.4.Энэ хуулийн 15.1-д заасан нэхэмжлэлийг шийдвэрлэхэд хүүхдийн тэтгэлгийг тогтоох болон хүүхдийн асрамжийн асуудлыг хамтад нь шийдвэрлэнэ.

17.2.Гэрлэлтийг хүчин төгөлдөр бусад тооцох тохиолдолд энэ хуулийн 6.4.2-т заасан асуудлыг хамтад нь шийдвэрлэнэ.

17.3.Нэхэмжлэгч нэхэмжлэл гаргасан бол гэрлэлтийг хүчин төгөлдөр бусад тооцуулах, гэрлэлт цуцлалтыг хүчин төгөлдөр бусад тооцуулах нэхэмжлэлтэй

хамт гэм хор учруулсны нөхөн төлбөр төлүүлэх асуудлыг шүүх шийдвэрлэж болно.

Үзэл баримтлалаас авч үзэхэд “Гэрлэлт цуцлуулах нэхэмжлэлийг 2020 онд 2176 шийдсэн бол мөн онд хүүхдийн тэтгэлэг гаргуулах тусдаа нэхэмжлэлийг 1333-ыг шийдсэн, 2021 онд гэрлэлт цуцлуулах 2823 хэргийг, хүүхдийн тэтгэлэг гаргуулах 1297 хэргийг тус тус шийдвэрлэсэнг харвал гэрлэлт цуцлуулахад хүүхдийн асуудлыг хамтад нь заавал шийдвэрлэхгүй байна.

-2017 оны шүүхийн шийдвэрүүдээс түүвэрлэн, гэрлэлт цуцлуулах нэхэмжлэл гаргахдаа хүүхдийн тэтгэлэг гаргуулах талаар давхар нэхэмжлээгүй 50 шүүхийн шийдвэрийг судалж үзэхэд, 10 шийдвэр буюу 20 хувь нь хүүхдийн тэтгэлэг гаргуулахаар шийдвэрлэж, 40 шүүхийн шийдвэр буюу 80 хувь нь хүүхдийн тэтгэлгийг шийдвэрлээгүй гаргасан байна.

-2022 оны шүүхийн шийдвэрүүдээс түүвэрлэн, гэрлэлт цуцлуулах нэхэмжлэл гаргахдаа хүүхдийн тэтгэлэг гаргуулах талаар давхар нэхэмжлээгүй 50 шүүхийн шийдвэрийг судалж үзэхэд, хүүхдийн тэтгэлэг гаргуулж шийдвэрлэсэн 5 шүүхийн шийдвэр буюу 10 хувь, 45 шүүхийн шийдвэр буюу нийт шүүхийн шийдвэрийн 90 хувь нь хүүхдийн тэтгэлгийг шийдвэрлэлгүй орхигдуулсан байна.” гэжээ.

Ийнхүү үзэл баримтлалд тусгасан дээрх хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн хүүхдийн эрх, ашиг сонирхлыг тэргүүн ээлжинд хамгаалах үүднээс холбогдох судалгаанд дурдсан бусад улсын туршлагаас судалж, шүүх гэрлэлт цуцлалтын хэргийг шийдвэрлэхдээ тэжээн тэтгэх, тэтгэлэг зэрэг хүүхэдтэй холбоотой асуудлыг нэхэмжлэгч нэхэмжлэл гаргаагүй байсан ч заавал хамтад нь шийдвэрлэх дээрх зохицуулалтыг хуулийн төсөлд тусгалаа олсон байгаа нь хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалахад хувь нэмрээ оруулах маш чухал, дэвшилтэт алхам болжээ гэж үзэхээр байна.

4.Шүүх дэх эвлэрүүлэн зуучлалаар гэрлэгчид шууд утгаар эвлэрэхээс гадна гэрлэлт цуцлалттай холбоотой бусад асуудал болох хүүхдийн асрамж, уулзах цаг, хүүхдийн тэтгэлэг, эд хөрөнгө хуваах асуудлыг тохиролцох боломжтой байдлаар тусгах шаардлагын хүрээнд:

33 дугаар зүйл.Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа

33.1.Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны зорилго нь энэ хуулийн 6.3.2-т заасан асуудлаар талууд тохиролцоход хүргэх болно.

33.2.Эвлэрүүлэн зуучлагч дараах тохиолдолд гэрлэлт цуцлах нэхэмжлэлийг шүүхэд шилжүүлнэ:

33.2.1.гэрлэгчид сүүлийн таваас доошгүй жил хамтран амьдраагүй болохыг шүүх тогтоосон;

33.2.2.Гэр бүлийн тухай хуульд заасны дагуу гэрлэгчид эвлэрэх боломжгүй буюу гэрлэгчдийн хэн нэгний байнгын хүчирхийлэл дарамтаас болж гэр бүлийн гишүүдийн амь нас, эрүүл мэнд болон хүүхдийн хүмүүжилд ноцтой аюул, хор уршиг учирч болзошгүй, эсхүл учирсан нь тогтоогдсон;

33.2.3.гэрлэгчид эвлэрүүлэх арга хэмжээ авсан хугацаанд энэ хуулийн 6.3.2-т заасан асуудлаар тохиролцоонд хүрээгүй.

34 дүгээр зүйл.Эвлэрүүлэн зуучлагчийн шийдвэр

34.1.Эвлэрүүлэн зуучлагч дараах шийдвэрийг гаргана:

34.1.1.гэрлэгчид энэ хуулийн 6.3.2-т заасан асуудлаар тохиролцоонд хүрээгүй бол хэргийг шүүхэд шилжүүлэх;

34.1.2.гэрлэгчид эвлэрч, гэрлэлт цуцлах нэхэмжлэлээс татгалзвал хэргийг хэрэгсэхгүй болгох;

34.1.3.гэрлэгчид энэ хуулийн 6.3.2-т заасан асуудлаар тохиролцоонд хүрсэн бол гэрлэлтийг цуцалж, холбогдох тохиролцоог гэрлэлт цуцалсан шийдвэрт тусгах.

34.2.Гэрлэгчид эвлэрсэн, эсхүл энэ хуулийн 6.4.2-т заасан асуудлаар тохиролцоонд хүрч, гэрлэлт цуцалсан бол эвлэрүүлэн зуучлагч холбогдох шийдвэрийг гаргаж, шүүгч уг эвлэрэл, цуцлалтыг баталсан захирамж гаргана.

Үзэл баримтлалд “Иргэний хэрэг шүүхээс үүсгэхээс өмнө болон дараа эвлэрүүлэн зуучлалаар заавал орох шаардлага байгаа нь талуудын сайн дурын үндсэн дээр эвлэрүүлэн зуучлал явуулах зарчимтай нийцэхгүй байна. Ийнхүү нийт эвлэрүүлэн зуучлалаар явуулсан хэргийн 88 хувь нь эвлэрдэггүй буюу шүүхээр цуцлуулж байгааг анхаарах шаардлага үүсчээ.

Эвлэрүүлэн зуучлал гэдэг бол бодитоор албадан эвлэрч цуцлуулахгүй байхад чиглэсэн зүйл биш гэрлэлт цуцлуулах тохиролцоогоо эвээр хийж, хүүхэд асрах, тэжээн тэтгэх асуудлыг эвээр шийдвэрлэх тухай асуудал болохыг анхаарах. Ингэвэл шүүхээр заавал ахиж оролгүй гэрлэлт цуцлуулах тохиролцоогоо эвийн журмаар хийх нөхцөл бүрдэнэ.” гэжээ.

Ийнхүү эвлэрүүлэн зуучлагч гэрлэлт цуцлалтын тохиролцоог хүүхдэд ээлтэйгээр хийдэг болох зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан нь үзэл баримтлалд тусгасан хэрэгцээ, шаардлагыг зарчмын хувьд хангахуйц байна гэж үзэв.

5.Гэр бүлийн холбогдолтой хэргийг шүүхээс шийдвэрлэхэд хүүхдийн эмзэг байдлыг харгалзаж, хүүхдийн сэтгэл зүйч оролцох, хүүхдэд шүүхээс асуулт тавихдаа хүүхдийн сэтгэл зүйчээр дамжуулан асуух зэрэг шаардлагын хүрээнд:

19 дүгээр зүйл.Сэтгэл зүйчийн оролцоо

19.1.Хүүхэд хамаарах гэр бүлийн хэргийг хянан шийдвэрлэхэд сэтгэл зүйчийг заавал оролцуулна.

19.2.Энэ хуулийн 19.1-д заасны дагуу сэтгэл зүйч хүүхэдтэй харилцаж, саналыг авч, тэмдэглэл үйлдэх бөгөөд хүүхэдтэй холбоотой асуудлаар шүүх хүүхдийн сэтгэл зүйчгүйгээр хүүхдээс асуулт асуухгүй байна.

Монгол Улсад гэр бүлийн холбогдолтой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хүүхэд хамаарах ажиллагаанд хүүхдийн сэтгэл зүйч оролцох эрх зүйн орчин байхгүй бөгөөд энэ талаарх зохицуулалтыг хуульчилж өгөхөөр тусгасан нь зарчмын хувьд зорилгодоо нийцэхүйц байна гэж үзлээ.

3.2.”Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ

Энэхүү шалгуур үзүүлэлтийн дагуу хуулийн төслийг бүхэлд нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хууль тогтоомжийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”-д заасан шаардлагад нийцүүлэн боловсруулсан байдлыг дараах байдлаар судалж үнэллээ.

1/Хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн тухайд:

“4 дүгээр зүйл.Хуулийн зарчим.

4.1.Энэ хуульд өөрөөр заагаагүй бол гэр бүлийн холбогдолтой хэргийг хянан шийдвэрлэхэд мэтгэлцэх зарчим болон шүүхээс мөрдөн шалгах ажиллагаа явуулах, хүүхдийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг тэргүүн ээлжид хамгаалах зарчим үйлчилнэ.

4.2.Хүүхдийн эрх ашгийн үүднээс хүүхэдтэй хамаарах хэргийг хянан шийдвэрлэхэд хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах байгууллагын төлөөлөгч, сэтгэлзүйч заавал оролцоно.” гэжээ.

-Хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн “Хуулийн зарчим” гэсэн нэршил оновчгүй байх тул “Гэр бүлийн холбогдолтой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зарчим” гэж, эсхүл 4.1, 4.2 дахь хэсэгт тусгасан агуулга бүрээр, тухайлбал, Мэтгэлцэх зарчим, Шүүх нотлох зарчим г.м-ээр тусад нь нэрлэж томъёолох;

-Хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт тусгасан зарчим нь мэтгэлцэх, шүүхээс мөрдөн шалгах ажиллагаа явуулах /шүүх нотлох/, хүүхдийн хууль ёсны, эрх ашиг сонирхлыг тэргүүн ээлжинд хамаарах гэсэн 3 өөр утга агуулга бүхий зарчмыг нэг хэсэгт багтаан томъёолсон нь Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалын 3.3.7-д заасан “хуулийн зарчмын утгыг бүрхэгдүүлсэн цөөн үгээр, эсхүл хэд хэдэн зарчимд хамаарах утгыг нэг зарчим болгох, хэтэрхий нуршсан олон үгээр томъёолохоос зайлсхийнэ.” гэсэнтэй нийцээгүй байна;

2/Хуулийн төсөлд мөрдөн шалгах ажиллагаа, хүүхдийн эрх ашиг, хүүхдийн эрх, ашиг сонирхол, хүүхдийн хууль ёсны эрх, ашиг сонирхол, сонирхогч тал, сонирхогч бусад этгээд, асрамж тогтоох, асран хамгаалагч тогтоох гэх зэрэг нэг ойлголтыг өөр өөр нэр томъёогоор тусгасан нь Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалын 4.1.1.1-т “Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэх;” гэж, 4.1.1.2-т “нэг нэр томъёогоор өөр өөр ойлголтыг, нэг ойлголтыг өөр өөр нэр томъёогоор илэрхийлэхгүй байх;” гэж тус тус заасан шаардлагыг хангаагүй байна.

Түүнчлэн хуулийн төслийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэгт тусгасан “тахир дутуу” гэснийг Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд нийцүүлж “хөгжлийн бэрхшээлтэй” гэж томъёолох;

3/Хуулийн төслийн 5 дугаар зүйлийн нэр нь Шүүх хуралдаан, хэрэг хянан шийдвэрлэх бусад ажиллагааг хаалттай явуулах гэсэн атлаа 5.1 дэх хэсэгт “Гэр бүлийн холбогдолтой хэрэг хянан шийдвэрлэх шүүх хуралдааныг хаалттай явуулна.” гэж зөвхөн шүүх хуралдааныг хаалттай явуулахаар тусгасан нь уг зүйлийн нэртэйгээ уялдахгүй байна;

4/Хуулийн төслийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэг, 6.3 дахь хэсэгт субъектийг эсхүл эхэнд, эсхүл хойно нь тусгасан байгааг анхаарч техникийн хувьд жигдлэн нэг мөр эхэнд тусгах нь зүйтэй;

5/Хуулийн төслийн 6.3.1-6.3.13 дахь заалтууд нь үйл үгээр төгссөн байх бөгөөд хуулийн төслийн 6.3.6-т тусгасан “хүйсийн өөрчлөлтийн улмаас гэрлэлт дуусгавар болсноос үүсэх энэ хуулийн 6.3.2-т заасан гэрлэлт цуцлахтай **холбоотой асуудал**” гэж нэр үгээр томьёолсныг жигдлэх;

6/Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн зорилт буюу 1.1 дэх хэсэг, 3.1 дэх хэсэгт “...эвлэрүүлэн зуучлалаар шийдвэрлэхтэй ...” гэж, 6.5, 6.6 дахь хэсэгт “...эвлэрүүлэн зуучлах ажиллагаагаар шийдвэрлүүлнэ.” гэж өөр өөр томьёолсныг жигдлэх;

7/Хуулийн төслийн 6.6 дахь хэсэгт тусгасан шүүхийн нэрийг Улсын Их Хурлаас 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр баталсан Шүүх байгуулах тухай хуульд заасан нэршлээр нэрлэх. Тухайлбал орон нутагт энгийн харьяаллын шүүх шийдвэрлэх нь ойлгомжтой тул уг хэсэгт тусгасан сум буюу сум дундын шүүх гэж тусгах шаардлагагүй бөгөөд нийслэлд Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан шатны шүүх гэж тусгахад хангалттай гэж үзэж байна;

8/Хуулийн төслийн 7 дугаар зүйлийн “Нэхэмжлэл, хүсэлт гаргах харьяалал” гэж нэрлэсэн атлаа уг зүйлд тусгасан агуулга нь “Нэхэмжлэл, хүсэлт гаргах нутаг дэвсгэрийн харьяалал” байх тул оновчтой нэрлэх.

Түүнчлэн хуулийн төслийн 7.1 дэх хэсэгт “энэ хуульд өөрөөр заагаагүй бол” гэсэн тодотгол тусгах;

9/Хуулийн төслийн 8 дугаар зүйлд тусгасан зохицуулалт нь гэр бүлийн холбогдолтой хэргийг хянан шийдвэрлэх шүүхийн харьяалал байх бөгөөд уг зүйлийн гарчгийг “Гэр бүлийн холбогдолтой хэргийг хянан шийдвэрлэх нутаг дэвсгэрийн харьяалал” гэсэн нь уялдахгүй байгааг уялдуулах.

Түүнчлэн хуулийн төслийн 8.1 дэх хэсэгт тусгасан “нэхэмжлэл, хүсэлтийг” гэснийг зүйлийн нэр, агуулгад нийцүүлэн “Гэр бүлийн холбогдолтой хэргийг” гэж өөрчлөх, мөн уг хэсэгт тусгасан шүүхийн нэрийг Шүүх байгуулах тухай хуульд заасан нэршлээр буюу нийслэлд Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан шатны шүүх аймагт сум дундын анхан шатны шүүх, суманд сум дундын шүүх гэсэн агуулгаар томьёолох;

Хуулийн төслийн 8.1, 8.2, 8.3 дахь хэсэгт Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, 16.2, 16.3 дахь хэсэгт заасан анхан шатны журмаар, давж заалдах журмаар хянан шийдвэрлэсэн гэсэн агуулга нэмэх;

10/Хуулийн төслийн 9 дүгээр зүйлийн “Хэрэг хянан шийдвэрлэх журам” гэсэн нэршлийг 9.1, 9.2 дахь хэсгийн агуулгад нийцүүлэн “Гэр бүлийн холбогдолтой хэрэг хянан шийдвэрлэх шүүх бүрэлдэхүүн” гэж өөрчлөх.

Мөн зүйлийн 9.1 дэх хэсэгт тусгасан эд хөрөнгө хуваах асуудал нь хуулийн төслийн 6.3.2-т тусгасан нэхэмжлэлээр шийдвэрлэх асуудал байна. Нөгөөтэйгүүр зүйлийн нэрний агуулгад нийцүүлэн “хэргийг” гэсэн агуулгаар нийцүүлэх.

Түүнчлэн 9.1 дэх хэсэг нь шүүгч дангаар болон бүрэлдэхүүнтэй шийдвэрлэх агуулга байх тул тусад нь томьёолох. Ингэхдээ эд хөрөнгө хуваах нэхэмжлэлтэй

холбоотой хэргийг ийнхүү 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэй шийдвэрлэх үндэслэл, шаардлага үзэл баримтлалд тодорхойгүй байгааг нягтлах нь зүйтэй гэж үзэв.

Хуулийн төслийн 9.2 дахь хэсэг нь нэг талаас хэрэг хянан шийдвэрлэх шүүх бүрэлдэхүүнтэй хамааралгүй, нөгөө талаас 9.2 дахь хэсэгт тусгасан ердийн журмаар шийдвэрлэх агуулгыг хуулийн төслийн 3.2-т тусгасантай давхардаж байна.

11/Хуулийн төслийн 12 дугаар зүйлийн 12.4 дэх хэсэгт “Энэ хуулийн 12.1-д заасан гэр бүлийн мөрдөн шалгах ажиллагааг Хүүхэд хамгааллын тухай хуулийн 18 дугаар зүйлд заасан нөхцөл байдлын үнэлгээ хийлгэхийг даалгасан захирамжийг шүүгч гаргаж, хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан, шаардлагатай тохиолдолд энэхүү үнэлгээг хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйчийг оролцуулсан багаар гүйцэтгүүлнэ.” гэж тусгасан нь найруулгын хувьд ойлгомжгүй байгаа нь хуулийг хэрэгжүүлэх, хэрэглэх субъектүүдэд ойлгомжгүй байдал үүсгэж болзошгүй байгааг анхаарах. Тухайлбал, гэр бүлийн мөрдөн шалгах ажиллагааг нөхцөл байдлын үнэлгээтэй хамтад нь хийлгэх агуулга уу, тусдаа агуулга уу гэдэг нь ойлгогдохооргүй байна;

12/Хуулийн төслийн 11, 12 дугаар зүйлүүдийг давхардуулан дугаарласнаас үүдэн 13 дугаар зүйлээс хойшхи дугаарлалтын алдаа гаргасан байгааг, мөн 13.3 дахь хэсгийг 2 удаа давхардуулан дугаарласан байгааг анхаарч залруулах;

14/Хуулийн төслийн 13 дугаар зүйлийн 13.5 дахь хэсэгт тусгасан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох оролцогчдид одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан “хүүхдийн эрх ашиг, сонирхлыг хамгаалах байгууллагын төлөөлөгч” гэсэн агуулгыг хассан нь одоо байгаагаасаа дордуулсан зохицуулалт байж болзошгүйг нягтлах;

15/Хуулийн төслийн 17.2 дахь хэсэг, 33.1 дэх хэсэг, 33.2.3 дахь заалт, 34.2 дахь хэсэгт хийсэн эшлэлийн алдааг засах;

16/Хуулийн төсөлтэй холбогдуулан хуулийн хэрэгжилтийг хангах зоихон байгуулалт, шилжилтийн үеийг зохицуулсан дагаж мөрдөх журмын зохицуулалтыг сайтар судалж, тусгах;

17/Хуулийн төслийн боловсруулалтын тухайд нийтлэг байдлаар найруулга зүй, хэл зүйн шаардлагыг хангаж боловсруулах.

3.3.“Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Хууль тогтоомжийн төслийн үр нөлөө үнэлэх аргачлалд заасан дараах стандарт асуултад хариулах замаар хуулийн төслийг бүхэлд нь үнэлж, хуулийн төслийн зохицуулалт өөр хоорондоо болон хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад хуульд нийцэж байгаа эсэхийг шалгах байдлаар уялдаа холбоог тогтоохыг зорьлоо.

1/Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх.

Хуулийн төслийн зохицуулалт хуулийн төслийн зорилттой зачрмын хувьд нийцэж байна гэж үзэв.

2/Хуулийн төслийн “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэгт “Гэр бүлийн тухай хууль” гэж нэмэх;

3/.Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх.

-Хуулийн төсөлтэй холбогдуулан дагалдуулж боловсруулсан Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зохицуулалт нь уг хуульд нэмэлт оруулах агуулга байх тул хуулийн төслийн нэрийг нэмэлт оруулах байдлаар өөрчлөх. Түүнчлэн уг хуулийн төслийн 1.8 дугаар зүйлийн 12 дахь хэсэгт тусгасан шүүхийн нэршлийг найруулгын хувьд Шүүх байгуулах тухай хуульд нийцүүлэн томьёолох;

-Хуулийн төсөлтэй холбогдуулан дагалдуулж боловсруулсан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим зүйл, хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн зохицуулалтаас үзэхэд зарим заалт хүчингүй болж байх тул нэрийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим зүйл, хэсэг, **заалтыг** хүчингүй болсонд тооцох тухай гэж нэрлэх;

4/.Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх.

-Хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт “Энэ хуулиар гэр бүлийн холбогдолтой иргэний хэргийг шүүх хэрэг үүсгэн хянан шийдвэрлэх, эвлэрүүлэн зуучлалаар шийдвэрлэх /цаашид "гэр бүлийн холбогдолтой хэрэг" гэх/-тэй холбогдсон харилцааг зохицуулна.” гэж тусгасан агуулга хуулийн төслийн 1.1 дэх хэсэгт тусгасан хуулийн зорилттой давхардсан;

-Хуулийн төслийн 6 дугаар зүйлийн 6.3.3-т “тэжээн тэтгэх, тэтгэлгийн хэмжээг өөрчлөн тогтоох, эсхүл нэмэлт тэтгэлэг тогтоох;” гэсэн нь 6.3.12-т “тэтгэлэг тогтоолгох, хүүхдийн тэтгэлгийн хэмжээг өөрчлүүлэх, нэмэлт тэтгэлэг тогтоолгох;” гэсэнтэй давхардсан;

-Хуулийн төслийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэгт “Гэр бүлийн эрх зүйн харилцаанаас үүссэн маргааныг энэ хуульд өөрөөр заагаагүй бол Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу ердийн журмаар шийдвэрлэнэ.” гэсэн нь хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 3.2-т “Энэ хуульд өөрөөр зааснаас бусад харилцааг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар зохицуулна. “ гэсэнтэй агуулгын хувьд давхардсан;

-Хуулийн төслийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэг, 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсэг, 15 дугаар зүйлийн 15.6 дахь хэсэг, 16 дугаар зүйлийн 16.6 дахь хэсэг, 17 дугаар зүйлийн 17.5 дахь хэсэг, 18 дугаар зүйлийн 18.3 дахь хэсэг тусгасан “Хариуцагч хоёр дахь удаа хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй бол хэргийг зохигчийн байхгүйд хянан шийдвэрлэж болно.” гэсэн зохицуулалт, 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсэг, 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсэг, 15 дугаар зүйлийн 15.7 дахь хэсэг, 16 дугаар зүйлийн 16.7 дахь хэсэг, 17 дугаар зүйлийн 17.6 дахь хэсэг, 18 дугаар зүйлийн 18.4 дэх хэсэгт тусгасан “Нэхэмжлэгч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр шүүх хуралдаанд ирээгүй, өөрийнхөө эзгүйд шүүх хуралдааныг хийх талаар шүүхэд бичгээр хүсэлт ирүүлээгүй бол хариуцагчийн хүсэлтээр шүүх хэргийн нотлох баримт болон бусад нөхцөл байдлыг харгалзан түүний эзгүйд хянан шийдвэрлэх, эсхүл нэхэмжлэлийг буцааж болно. Нэхэмжлэлийг буцаасан тохиолдолд шүүх тогтоол, шүүгч захирамж гаргана.” гэсэн зохицуулалт агуулгыг ийнхүү давхардуулан тус бүрт нь томьёолох шаардлагагүй.

Харин эдгээр зохицуулалт дахь агуулгыг хууль зүйн техникийн хувьд Шүүх хуралдаанд ирэх, эсхүл Шүүх хуралдаанд ирээгүйгээс гарах холбогдол гэх зэрэг

агуулгаар нэг зүйл болгон нэгтгэх нь оновчтой гэж үзэж байна;

-Хуулийн төслийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсэгт “Энэ хуулийн 15.1-д заасан нэхэмжлэлийг шийдвэрлэхэд хүүхэд долоо ба түүнээс дээш нас хүрсэн бол түүний саналыг харгалзана.” гэсэн нь Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 40 дүгээр зүйлийн 40.3 дахь хэсэгтэй, хуулийн төслийн 16 дугаар зүйлийн 16.4 дэх хэсэгт 16.4.Шүүх эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан, эсхүл хасуулсан этгээдийн эрхийг сэргээхдээ зан үйлд нөлөөлөх сургалтад хамрагдсан эсэх болон Гэр бүлийн тухай хуульд заасан нөхцөл байдал үүссэн эсэхийг харгалзан үзнэ.” гэсэн нь Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 44 дүгээр зүйлийн 44.2 дахь хэсэгтэй тус тус давхардсан.

Ер нь Гэр бүлийн тухай хуулийн төсөл болон энэхүү процессийн хуулийн төсөл хоорондын зохицуулах зарим харилцаа, уялдаа холбоог дахин сайтар нягтлах шаардлагатай;

5/Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх.

-Хуулийн төслийн 6 дугаар зүйлд Гэр бүлийн холбогдолтой хэрэг маргааныг хүсэлтээр үүсэх болон нэхэмжлэлээр үүсэх хэрэг маргаан гэж төрлөөр нь ангилсан байх бөгөөд ийнхүү ялгаж ангилж байгаагийн ач холбогдол, үр дагавар тодорхойгүй байна;

-Хуулийн төсөлтэй холбогдуулан дагалдуулж боловсруулсан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим зүйл, хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслөөр Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 135 дугаар зүйлийн 135.2.1-135.2.13 дахь заалтыг хүчингүй болсонд тооцохоор тусгажээ.

Гэтэл Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 135 дугаар зүйлийн 135.2.5-т “осол гэмтэл гарсан эсэх,” 135.2.6-д “хүний ажиллаж байсан байдал,” гэж заасан эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдлыг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар тогтоохоор заасан бөгөөд энэ нь гэр бүлийн холбогдолтой хэрэг маргаанд хамаарахгүй байхад эдгээрийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим зүйл, хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслөөр хүчингүй болгохоор тусгасан нь хуулийн хийдэл, зөрчил үүсгэхээр байна.

Түүнчлэн хуулийн төслийн 6 дугаар зүйлийн 6.1.5-д тусгасан нас тогтоох хүсэлт мөн гэр бүлийн холбогдолтой хэрэг маргаанд хамаарах эсэх нь эргэлзээтэй байна;

- Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 192 дугаар зүйлд заасан Гэр бүлийн холбогдолтой хэргийн харьяалал гэсэн хэргийг Гэр бүл, хүүхдийн хэргийн шүүх харьяалан шийдвэрлэх эсэх талаар хуулийн төсөлд тусгаагүй орхигдуулсан байна.

6/Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх.

Хуулийн төслийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсэгт улсын тэмдэгтийн хураамжтай холбоотой зохицуулалт тусгасан байх бөгөөд энэ нь одоо хүчин төгөлдөр

мөрдөгдөж буй Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зохицуулалт болно.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ:

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд хүүхдийн эрхийг хамгаалах талаар НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенц (1989 он), НҮБ-ын насанд хүрээгүй этгээдийг хорихоос зайлсхийх дүрэм (1990 он), Насанд хүрээгүй хүмүүсийн талаар шүүн таслах ажиллагаа явуулахтай холбогдуулан НҮБ-аас гаргасан стандартын наад захын журам (Бээжингийн журам, 1985 он) зэрэгт заасан эрх зүйн хэм хэмжээнд нийцүүлэн өсвөр насны сэжигтнийг дуудан ирүүлэх зохицуулалтыг, Насанд хүрээгүй хүүхдийг хяналтад өгөх таслан сэргийлэх арга хэмжээг, өсвөр насны сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн хувийн мэдээллийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нууцлах зохицуулалтыг өсвөр насны шүүгдэгчид холбогдох хэргийг шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагаанд баримтлах нийтлэг шаардлага гэж хуульчилсан байсныг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх болгож, эрүүгийн процессын ажиллагаанд баримтлах нийтлэг шаардлага болгон хүрээг тэлж өөрчилсөн, түүнчлэн зайлшгүйгээс бусад тохиолдолд насанд хүрээгүй хүнийг түүний сургууль зэрэг газарт баривчлахгүй байх, өсвөр насны сэжигтэн яллагдагч, шүүгдэгчийн хууль ёсны төлөөлөгчөөр оролцуулах боломжгүй, эсхүл тийм хүн байхгүй тохиолдолд хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн байгууллагын ажилтныг хууль ёсны төлөөлөгчөөр томилон оролцуулах зохицуулалтуудыг шинээр нэмснээс гадна өсвөр насны сэжигтэн, яллагдагчаас мэдүүлэг авах эрх зүйн зохицуулалтыг хуульчлан, хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн оролцоо, мэдүүлэг авах ажиллагаанд тэдний эрх, үүргийг тусгайлан тусгасан байна.

Эдгээр эрх зүйн зохицуулалтууд нь олон улсын эрх зүйн хэм хэмжээнд үндэсний хууль тогтоомжийг нийцүүлэхэд чиглэсэн байна.

Иймээс хуулийн төсөлд тусгагдсан Хууль тогтоомжийн тухай хуулиар тогтоосон шаардлагыг хангахад анхаарах шаардлагатай гэж үзсэн 5 заалтын хүрээнд хуулийн төслийн үнэлгээг хийлээ.

№	Зүйл, заалт	Зохицуулалт
1.	2/12.3 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт	8.Арван зургаагаас арван найман настай сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг албадан ирүүлэхдээ эцэг, эх харгалзан дэмжигч, эсхүл хууль ёсны төлөөлөгчид мэдэгдэх бөгөөд тэдний байхгүйд шүүхийн шийдвэрийг дагуу танилцуулах арга хэмжээ авна.
2.	3/14 ¹ дүгээр зүйл: “14 ¹ дүгээр зүйл.	4.Өсвөр насны яллагдагч, шүүгдэгчийг хяналтад байнга байлгах үүрэг хүлээсэн хүн хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд зөрчлийн тухай хуульд заасан журмаар мөнгөн торгууль ногдуулна.
3.	1/3.3 ¹ дугаар зүйл.	1.Нийслэлд үйлдэгдсэн Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан өсвөр насны хүн холбогдсон эрүүгийн хэргийг нийслэлд Шүүх байгуулах тухай хуулийн 2 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 1-д заасан нутаг дэвсгэрийн нэгжийнхийг Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан шатны тойргийн шүүх, 2 дугаар

		зүйлийн 1 дэх хэсгийн 3, 4 дэх хэсэгт заасан нутаг дэвсгэрийн нэгжийнхийг тухайн нутаг дэвсгэрт байрших эрүүгийн хэргийн анхан шатны шүүх, орон нутагт сум дундын болон сум дахь сум дундын анхан шатны шүүх харьяалан шийдвэрлэнэ.
		2.Энэ хуулийн 3.3 ¹ дүгээр зүйлийн 1-д заасан эрүүгийн хэргийг Гэр бүл, хүүхдийн хэргийн давж заалдах шатны шүүх давж заалдах журмаар хянан шийдвэрлэнэ.
4.	18.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг	2.Өсвөр насны сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгчийг оролцуулахаас гадна сэжигтэн, яллагдагчийн сэтгэл зүйн байдалд эргэлзээ төрвөл мэдүүлэг авах ажиллагаанд сэтгэл зүйчийг оролцуулна.

Гэр бүлийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээнээс үзэхэд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2-т зааснаар нэхэмжлэгч гэж хуульд заасан эрх, эрх чөлөө, хуулиар хамгаалагдсан ашиг сонирхол нь зөрчигдсөн гэж үзэж эрхээ сэргээлгэхээр өөрийн болон бусдын нэрийн өмнөөс нэхэмжлэл гаргагч этгээдийг хэлэх бөгөөд гэр бүлийн холбогдолтой хэрэгт зөвхөн хуульд заасан эрх, эрх чөлөө, хуулиар хамгаалагдсан ашиг сонирхол нь зөрчигдсөн гэж үзэж эрхээ сэргээлгэхээр өөрийн болон бусдын нэрийн өмнөөс нэхэмжлэл гаргагч л нэхэмжлэл гаргаж болгохоор байгаа нь гэрлэгчид төдийгүй, хүүхэд, төрөл садангийн хүн, прокурор, орон нутгийн байгууллага зэрэг сонирхогч этгээд нэхэмжлэл гаргах эрхтэй буюу гуравдагч этгээдийн нэхэмжлэл гаргах эрх, түүнчлэн шүүх өөрийн санаачилгаар авч болох эрхийг бий болгосноор тухайн маргааны улмаас хүүхдийн эрх, ашиг сонирхол зөрчигдсөн байдлыг цаг алдалгүй мэдэгдэх ач холбогдолтой юм.

Ингэснээр хүчирхийлэл үйлдэгдсээр байтал нотлохыг шаардаж, гэрлэлт цуцлах нэхэмжлэлийг хүлээж авахгүй байх талаарх Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 132 дугаар зүйлийн 132.4 дэх хэсэг, Гэр бүлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэг нь тус тус хүүхдийн болон гэр бүлийн гишүүдийн эрх, эрх чөлөөг хязгаарласан зохицуулалтын болон нийт гэрлэлтийн бүртгэлд оногдох гэрлэлт цуцлалтын хувь хэмжээ 27-33 хувь байх боловч эдгээр маргааны 60 орчим хувьд нь хүүхдийн тэтгэлгийн асуудлыг хамтад нь шийдвэрлэдэггүй байдлаас үүдсэн сөрөг үр дагавар буурна гэж үзэж байна. Хэрэгжилтийн үнэлгээнээс харахад 2022 оны шүүхийн шийдвэрүүдээс түүвэрлэн, гэрлэлт цуцлуулах нэхэмжлэл гаргахдаа хүүхдийн тэтгэлэг гаргуулах талаар давхар нэхэмжлээгүй 50 шүүхийн шийдвэрийг судалж үзэхэд, хүүхдийн тэтгэлэг гаргуулж шийдвэрлэсэн 5 шүүхийн шийдвэр буюу 10 хувь, 45 шүүхийн шийдвэр буюу нийт шүүхийн шийдвэрийн 90 хувь нь хүүхдийн тэтгэлгийг шийдвэрлэлгүй орхигдуулсан байна⁸.

Түүнчлэн одоо мөрдөгдөж буй Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн хүрээнд гэр бүлийн маргааныг шүүхийн дэргэдэх эвлэрүүлэн зуучлалаар шийдвэрлэх асуудал нь гэрлэгчдийг гэрлэлтээ цуцлуулахгүй байхад чиглэгдсэн

⁸ Гэр бүлийн харилцаанаас үүссэн зарим төрлийн иргэний хэргийн шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ, 19 дэх тал.

байх боловч бодит хэрэгжилтийг авч үзвэл нийт гэр бүлийн маргааныг эвлэрүүлэн зуучлалд шилжүүлсэн тохиолдлын 90 орчим хувь нь амжилтгүй болсон байна. Энэ нь олон улсын жишигт гэр бүлээ цуцлуулах гэж буй гэрлэгчид бодит байдлаар эвлэрч цуцлуулахгүй байхад биш эвлэрүүлэн зуучлах ажиллагааны явцад гэрлэлтээ цуцлуулах гэж буй эхнэр, нөхөр гэрлэлт цуцлалтаа эвийн журмаар хийж, хүүхэд, эд хөрөнгийн асуудлаа эвээр тохиролцох нөхцөлийг бүрдүүлэхэд зорьдог байдлаас өөрөөр хэрэгжиж байгаатай холбоотой гэж үзэж болно.

Иймээс гэр бүл, хүүхдийн хэргийн бие даасан шүүх байгуулах асуудал хүний эрхийн, хүүхдийн эрх, эрх ашгийг хамгаалахад чиглэсэн үйл ажиллагаа гэж харж болох юм.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь 7 зүйлтэй бөгөөд дараах зүйл заалтууд нь агуулгын, зөв бичгийн хувьд алдаатай томъёологдсон нь хуулийн шаардлага хангахгүй байна гэж үзлээ. Үүнд:

1/Хуулийн төслийн 12.3 дугаар зүйлийн 8 дахь хэсэг

Хуулийн төсөлд “8.Арван зургаагаас арван найман настай сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг албадан ирүүлэхдээ эцэг, эх харгалзан дэмжигч, эсхүл хууль ёсны төлөөлөгчид мэдэгдэх бөгөөд тэдний байхгүйд шүүхийн шийдвэрийг дагуу танилцуулах арга хэмжээ авна.” гэж заасан байгаа нь шүүхийн шийдвэрийг “юуны” дагуу танилцуулах нь тодорхойгүй буюу агуулга орхигдуулсан шинжтэй байна.

2/Хуулийн төслийн 14¹ дүгээр зүйл: “14¹ дүгээр зүйл

Өсвөр насны яллагдагч, шүүгдэгчийг хяналтад байлгах” заалтын хүрээнд “4.Өсвөр насны яллагдагч, шүүгдэгчийг хяналтад байнга байлгах үүрэг хүлээсэн хүн хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд зөрчлийн тухай хуульд заасан журмаар мөнгөн торгууль ногдуулна.” гэсэн нь Зөрчлийн хууль буюу оноосон нэрийг жижиг үсгээр бичсэн алдаа гаргасныг залруулах шаардлагатай гэж үзэж байна.

3/Хуулийн төслийн 1 дүгээр заалтын 1/3.3¹ дугаар зүйл.

Хүүхэд холбогдсон хэргийн нутаг дэвсгэрийн харьяалал заалтад “1.Нийслэлд үйлдэгдсэн Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан өсвөр насны хүн холбогдсон эрүүгийн хэргийг нийслэлд Шүүх байгуулах тухай хуулийн 2 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 1-д заасан нутаг дэвсгэрийн нэгжийнхийг Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан шатны тойргийн шүүх⁹, 2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3, 4 дэх хэсэгт заасан нутаг дэвсгэрийн нэгжийнхийг тухайн нутаг дэвсгэрт байрших эрүүгийн хэргийн анхан шатны шүүх, орон нутагт сум дундын болон сум дахь сум дундын анхан шатны шүүх харьяалан шийдвэрлэнэ.” мөн “2.Энэ хуулийн 3.3¹ дүгээр зүйлийн 1-д заасан эрүүгийн хэргийг Гэр бүл, хүүхдийн хэргийн давж заалдах шатны шүүх давж заалдах журмаар хянан шийдвэрлэнэ.” гэж зааснаас харахад Нийслэл дэх Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан шатны тойргийн шүүх нь Нийслэлийн Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан, Сүхбаатар, Чингэлтэй, Хан-Уул дүүргийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгжийг харьяалах бол Нийслэлийн Багахангай, Налайх дүүргийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгжийг Багахангай, Налайх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүх, Нийслэлийн Багануур дүүргийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгжийг Багануур дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх

⁹ Эх сурвалж: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17140721145671>

харьяалан шийдвэрлэхээр, орон нутагт сум дундын болон сум дахь сум дундын анхан шатны шүүх харьяалан шийдвэрлэхээр тус тус тусгажээ.

Энэ нь иргэний хэргийн шүүхээр шийдвэрлэгдэж буй нийт хэргийн 10 гаруй хувийг эзэлж буй Гэр бүлийн тухай хуулийн хүрээнд шийдвэрлэгдэж буй маргааныг бие даасан шүүхийн харьяалалд шилжүүлэх замаар шүүхийн ачааллыг бууруулах зорилго агуулсан авч нийслэлийн төвийн 6 дүүргээс бусад газарт иргэний хэргийн анхан шатны шүүх Гэр бүлийн тухай хуулийн хүрээнд үүссэн маргааныг шийдвэрлэхээр зохицуулагдсан нь гэр бүл, хүүхдийн хэргийн шүүхийн үйл ажиллагаа зөвхөн Улаанбаатар хотын төвийн 6 дүүргийн хэмжээнд бүрэн утгаараа хэрэгжих нөхцөлийг бүрдүүлсэн байна. Түүнчлэн гэр бүл, хүүхдийн хэргийн давж заалдах шатны шүүх нь Улаанбаатар хотод байршиж, улсын хэмжээнд хэрэг шийдвэрлэхээр хуульчилсан нь Монгол Улсын Их Хурлын 2020 оны "Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай" 02 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарь"-ийн 3.3.1-д "шүүхийг тойргийн зарчмаар байгуулахдаа иргэний шүүхэд хандах эрхийн баталгааг бодитой хангах, шүүгчийн ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, шүүгчийг мэргэшүүлэх, шүүхийн үйлчилгээг иргэдэд ойртуулж хүртээмжтэй болгох үндсэн зарчимд нийцүүлэх чиглэл"-ийн "шүүхийн үйлчилгээг иргэдэд ойртуулах" зарчимд хэрхэн нийцэхийг дахин судлах шаардлагатай гэж үзэж байна. Ялангуяа хүүхэд нь эдийн засаг болон бусад эрхийн хувьд бусдаас /эцэг, эх, асран хамгаалагч/ хараат байдаг явдал нь хуулийн үр нөлөөнд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна.

Түүнчлэн гадаад орнуудад гэр бүлийн хувийн эрх зүйн хэрэг маргааныг Гэр бүлийн шүүхэд харьяалан шийдвэрлэж байхад, хүүхдийн үйлдсэн гэмт хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг ердийн эрүүгийн хэргийн шүүхээр хянан шийдвэрлэхээс илүүтэй Гэр бүл, хүүхдийн шүүхэд харьяалан шийдвэрлэж байгаа туршлагыг нэвтрүүлж¹⁰ байгаа нь орон нутагт буюу төвийн 6 дүүргээс бусад газарт байрлах шүүхүүдийн шүүгч нарт зөвхөн гэр бүл, хүүхдийн чиглэлээр иргэн, эрүүгийн эрх зүйн маргаанаар дагнан ажиллах нөхцөл, боломж бүрдэх эсэх нь тодорхойгүй байна. Тухайлбал, Гэр бүлийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлангаас харахад хүүхэд хохирогч, шүүгдэгч болсон, мөн гэр бүлийн хүчирхийллийн эрүү, зөрчлийн хэргийг Гэр бүл, хүүхдийн шүүх шийдэх бол нийт ойролцоогоор 1300 эрүү, зөрчлийн хэргийн харьяалал тус шүүхэд шилжихээр буюу нэг жилд иргэний хэргийн шүүхээр шийдвэрлэгдэж буй хэрэг, маргааны тоотой харьцуулахад харьцангуй цөөн эрүү, зөрчлийн хэрэг байгаад асуудал оршиж байна.

4/Хуулийн төслийн 18.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлд "2.Өсвөр насны сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгчийг оролцуулахаас гадна сэжигтэн, яллагдагчийн сэтгэл зүйн байдалд эргэлзээ төрвөл мэдүүлэг авах ажиллагаанд сэтгэл зүйчийг оролцуулна." гэж заажээ.

Монгол Улсын хувьд, гэр бүл, хүүхдийн сэтгэлзүйчийн оролцоог шаардсан зохицуулалт байхгүй байх тул энэ талаарх бусад улсын жишиг зохицуулалтуудаас жишээ аван эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хүүхдийн хууль ёсны

¹⁰ ГЭР БҮЛ, ХҮҮХДИЙН ХОЛБОГДОЛТОЙ ХЭРГИЙГ ШҮҮХЭЭС ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ ХУУЛЬ ТОГТООМЖИД ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВРЫН ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН тайлан. 2024 он.

эрх, ашиг сонирхлыг тэргүүн ээлжид хамгаалах зарчим үйлчлэхээр тусгахыг зорьжээ. Ялангуяа хүүхдийн эрх, ашиг, сонирхлыг хамгаалах үүднээс хүүхэдтэй хамаарах хэргийг хянан шийдвэрлэхэд хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах байгууллагын төлөөлөгч, сэтгэлзүйчийн оролцоог хангах зорилготой байна. Энэ төрлийн зохицуулалт тухайлбал, БНСУ-ын хувьд захиргааны журмаар цуцлах гэж гэрлэгчид гэрлэлтээ цуцлуулахаас өмнө сэтгэлзүйн зөвлөгөө авсан байхыг шаарддаг бөгөөд зөвшилцөх хугацаа нь хүүхэд байгаа бол 3 сар, хүүхэд байхгүй бол 1 сарын хугацаатай байдаг байна.

Харин уг хуулийн зохицуулалтыг хэрэгжүүлэхэд гарах хүний нөөцийн болон зардлыг нарийвчлан тооцоолох шаардлагатай. Ялангуяа анхан шатны шүүхийн түвшинд орон нутагт үйл ажиллагаа явуулж буй сэтгэлзүйч мэргэжилтний нөөц, мөн давж заалдах шатны шүүхээр маргаанаа шийдвэрлүүлэхээр орон нутгаас Улаанбаатар хотод ирэх, үйлчилгээ үзүүлэх зардал зэргийг тодорхой тусгах нь хуулийн хэрэгжилтийг үр нөлөөтэй байлгахад чухал нөлөөтэй юм.

ТАВ.ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

Хуулийн төсөлд сонгож үнэлсэн шалгуур үзүүлэлт бүрээр дүгнэлт хийж, зөвлөмж боловсрууллаа.

ДҮГНЭЛТ:

Зорилгод хүрэх байдал: Монгол Улсын Их Хурлаас 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр баталсан Шүүх байгуулах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-иар Нийслэл дэх Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан шатны тойргийн шүүх, улсын хэмжээнд Гэр бүл, хүүхдийн хэргийн давж заалдах шатны шүүхийг тус тус байгуулсан зохицуулалт 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжих гэж байгаатай холбогдуулан Гэр бүлийн холбогдолтой хэргийг шүүхээс хянан шийдвэрлэх ажиллагааны талаарх хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, Гэр бүл, хүүхдийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хууль тогтоомжийн бусад улсын харьцуулсан судалгаа зэрэгт үндэслэн хэрэг хянан шийдвэрлэх онцлог ажиллагааг зохицуулсан процессийн хуулийн төслийг боловсруулах хэрэгцээ, шаардлагыг илэрхийлсэн үзэл баримтлалыг тодорхойлж, түүнд нийцүүлэн хуулийн төслийг боловсруулсан нь зарчмын хувьд үзэл баримтлалд тодорхойлсон хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна гэж үзлээ.

Харин хуулийн төслийн зорилгодоо хүрэх байдлыг бүрэн хангах талаарх зарим зохицуулалт, тухайлбал, энэхүү үнэлгээний тайлангийн “Зорилгодоо хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үр нөлөөг үнэлсэн хэсэгт тусгасан зарим зохицуулалтыг анхаарах шаардлагатай гэж үзэв.

Ойлгомжтой байдал: Хуулийн төслийн зарим зохицуулалт Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хууль тогтоомжийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”-д заасан шаардлагыг бүрэн хангаагүй байна гэж дүгнэлээ. /Үнэлгээний тайлангийн 16-18 дахь хуудас/

Харилцан уялдаа: Хууль тогтоомжийн төслийн үр нөлөө үнэлэх аргачлалд заасан стандарт асуулгад хариулах замаар хуулийн төслийн уялдаа холбоог бүхэлд

нь шалгасан. Үүнээс хуулийн төсөлд хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх, хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх, хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх гэсэн асуултуудын хариултууд зөрчилтэй гарснаас үзэхэд эдгээр зөрчлийг арилгаж, харилцан нийцэх байдлыг хангах нь зүйтэй байна. /Үнэлгээний тайлангийн 19-21 дэх хуудас/

ЗӨВЛӨМЖ:

Хуулийн төслийн зарим зохицуулалтыг тодорхой болгох, холбогдох хуульд нийцүүлэх, зарим зохицуулалтыг өөрчлөх зэргээр хуулийн төслийг хуулийн төслийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах улмаар хуулийн төслийг боловсронгуй болгох, чанарыг сайжруулах зорилгоор дараах зөвлөмжийг хууль санаачлагчид өгч байна.

Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийн тухайд:

1.Хуулийн төслийн үзэл баримтлал болон дэлгэрэнгүй танилцуулгад хуулийн төслийн төрлийн талаар тайлбарлаж тодорхой тусгах;

2.Хуулийн төслийн дэлгэрэнгүй танилцуулгыг хэт товч байдлаар хийсэн байгааг анхаарч Хууль тогтоомжийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.3 дахь хэсэгт заасан мэдээлэл бүрээр тухайлбал, зохицуулахаар тусгасан харилцааны агуулга, зохицуулалтыг хэрхэн ойлгох тухай; нэр томьёо, ухагдахууны үүслийн талаар тодорхой тусгах;

3.Хуулийн төсөлд “**Мөрдөн шалгах ажиллагаа**” гэж нэрлэсэн нь оновчгүй, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд “мөрдөн шалгах ажиллагаа” гэсэн нэр томьёог тодорхойлсон байгааг анхаарч, гэр бүлийн холбогдолтой иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд илүү нийцүүлэн оновчтой нэршлээр тодорхойлоход анхаарах нь зүйтэй байна. Тухайлбал, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд Шүүх нотлох зарчим гэж заасныг анхаарах.

Түүнчлэн хуулийн төслийн 4 дүгээр зүйлд тусгасан мөрдөн шалгах ажиллагаа явуулах зарчмыг хэрэгжүүлэх процессийг илүү тодорхой тусгах;

4.Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуульд заасан Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэхтэй холбоотой эрүүгийн хэрэг, зөрчлийн хэргийг уг шүүхэд харьяалуулах эсэх талаар нягтлан судлах;

5.Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл энэхүү процессийн хуулийн төсөлтэй хамтад нь хэлэлцэх тохиолдолд уг хуулийн төслөөс энэхүү хуулийн төсөлд “сонирхогч тал” гэж томьёолсон нэр томьёог эшлэх байдлаар тусгах, эсхүл шаардлагатай тохиолдолд энэхүү хуулийн төсөлд нэр томьёоны тодорхойлолт байдлаар тусгах;

6.Хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн “Хуулийн зарчим” гэсэн нэршлийг “Гэр бүлийн холбогдолтой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зарчим” гэж, эсхүл 4.1, 4.2 дахь хэсэгт тусгасан агуулга бүрээр, тухайлбал, Мэтгэлцэх зарчим, Шүүх нотлох зарчим, Хүүхдийн хууль ёсны, эрх ашиг сонирхлыг тэргүүн ээлжинд хамгаалах зарчим г.м-ээр агуулга бүрээр тусад нь нэрлэж томьёолох;

7.Хуулийн төсөлд мөрдөн шалгах ажиллагаа, хүүхдийн эрх ашиг, хүүхдийн эрх, ашиг сонирхол, хүүхдийн хууль ёсны эрх, ашиг сонирхол, сонирхогч тал, сонирхогч бусад этгээд, асрамж тогтоох, асран хамгаалагч тогтоох гэх зэрэг нэг ойлголтыг өөр өөр нэр томъёогоор тусгасан байгааг анхаарах

Түүнчлэн хуулийн төслийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэгт тусгасан “тахир дутуу” гэснийг Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд нийцүүлж “хөгжлийн бэрхшээлтэй” гэж томъёолох;

8.Хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг 5 дугаар зүйлийн нэр, агуулгатай уялдуулах;

9.Хуулийн төслийн 6.6 дахь хэсэгт тусгасан шүүхийн нэрийг Улсын Их Хурлаас 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр баталсан Шүүх байгуулах тухай хуульд заасан нэршлээр нэрлэх. Тухайлбал орон нутагт энгийн харьяаллын шүүх шийдвэрлэх нь ойлгомжтой тул уг хэсэгт тусгасан сум буюу сум дундын шүүх гэж тусгах шаардлагагүй бөгөөд нийслэлд Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан шатны шүүх гэж тусгахад хангалттай гэж үзэж байна;

10.Хуулийн төслийн 7 дугаар зүйлийн “Нэхэмжлэл, хүсэлт гаргах харьяалал” гэж нэрлэсэн атлаа уг зүйлд тусгасан агуулга нь “Нэхэмжлэл, хүсэлт гаргах нутаг дэвсгэрийн харьяалал” байх тул оновчтой нэрлэх.

Түүнчлэн хуулийн төслийн 7.1 дэх хэсэгт “энэ хуульд өөрөөр заагаагүй бол” гэсэн тодотгол тусгах;

11.Хуулийн төслийн 8 дугаар зүйлд тусгасан зохицуулалт нь гэр бүлийн холбогдолтой хэргийг хянан шийдвэрлэх шүүхийн харьяалал байх бөгөөд уг зүйлийн гарчгийг “Гэр бүлийн холбогдолтой хэргийг хянан шийдвэрлэх нутаг дэвсгэрийн харьяалал” гэсэн нь уялдахгүй байгааг уялдуулах.

Түүнчлэн хуулийн төслийн 8.1 дэх хэсэгт тусгасан “нэхэмжлэл, хүсэлтийг” гэснийг зүйлийн нэр, агуулгад нийцүүлэн “Гэр бүлийн холбогдолтой хэргийг” гэж өөрчлөх, мөн уг хэсэгт тусгасан шүүхийн нэрийг Шүүх байгуулах тухай хуульд заасан нэршлээр буюу нийслэлд Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан шатны шүүх аймагт сум дундын анхан шатны шүүх, суманд сум дундын шүүх гэсэн агуулгаар томъёолох;

Хуулийн төслийн 8.1, 8.2, 8.3 дахь хэсэгт Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, 16.2, 16.3 дахь хэсэгт заасан анхан шатны журмаар, давж заалдах журмаар хянан шийдвэрлэсэн гэсэн агуулга нэмэх;

12.Хуулийн төслийн 9 дүгээр зүйлийн “Хэрэг хянан шийдвэрлэх журам” гэсэн нэршлийг 9.1, 9.2 дахь хэсгийн агуулгад нийцүүлэн “Гэр бүлийн холбогдолтой хэрэг хянан шийдвэрлэх шүүх бүрэлдэхүүн” гэж өөрчлөх.

Түүнчлэн 9.1 дэх хэсэг нь шүүгч дангаар болон бүрэлдэхүүнтэй шийдвэрлэх агуулга байх тул тусад нь томъёолох. Ингэхдээ эд хөрөнгө хуваах нэхэмжлэлтэй холбоотой хэргийг ийнхүү 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэй шийдвэрлэх үндэслэл, шаардлага үзэл баримтлалд тодорхойгүй байгааг нягтлах;

Хуулийн төслийн 9.2 дахь хэсэг нь нэг талаас хэрэг хянан шийдвэрлэх шүүх бүрэлдэхүүнтэй хамааралгүй, нөгөө талаас 9.2 дахь хэсэгт тусгасан ердийн

журмаар шийдвэрлэх агуулгыг хуулийн төслийн 3.2-т тусгасантай давхардаж байх тул хасах;

13.Хуулийн төслийн 13 дугаар зүйлийн 13.5 дахь хэсэгт тусгасан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох оролцогчдид одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан “хүүхдийн эрх ашиг, сонирхлыг хамгаалах байгууллагын төлөөлөгч” гэсэн агуулгыг хассан нь одоо байгаагаасаа дордуулсан зохицуулалт байж болзошгүйг нягтлах;

14.Хуулийн төслийн 17.2 дахь хэсэг, 33.1 дэх хэсэг, 33.2.3 дахь заалт, 34.2 дахь хэсэгт хийсэн эшлэлийн алдааг засах;

15.Хуулийн төсөлтэй холбогдуулан хуулийн хэрэгжилтийг хангах зоихон байгуулалт, шилжилтийн үеийг зохицуулсан дагаж мөрдөх журмын зохицуулалтыг сайтар судалж, тусгах;

16.Хуулийн төслийн боловсруулалтын тухайд нийтлэг байдлаар найруулга зүй, хэл зүйн шаардлагыг хангаж эцэслэн боловсруулах;

17.Хуулийн төслийн давхардлыг арилгах. /Үнэлгээний тайлангийн 19-20 дахь хуудас/;

Ер нь Гэр бүлийн тухай хуулийн төсөл болон энэхүү процессийн хуулийн төсөл хоорондын зохицуулах зарим харилцаа, уялдаа холбоог дахин сайтар нягтлах шаардлагатай;

18.Хуулийн төслийн 6 дугаар зүйлд Гэр бүлийн холбогдолтой хэрэг маргааныг хүсэлтээр үүсэх болон нэхэмжлэлээр үүсэх хэрэг маргаан гэж төрлөөр нь ангилсан байх бөгөөд ийнхүү ялгаж ангилж байгаагийн ач холбогдол, үр дагавар тодорхойгүй байгааг анхаарч энэ талаар тодорхой тусгах.

Түүнчлэн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 192 дугаар зүйлд заасан Гэр бүлийн холбогдолтой хэргийн харьяалал гэсэн хэргийг Гэр бүл, хүүхдийн хэргийн шүүх харьяалан шийдвэрлэх эсэх талаар хуулийн төсөлд тусгаагүй орхигдуулсан байгааг анхаарах.

19.Хуулийн төслийн 6 дугаар зүйлийн 6.1.5-д тусгасан нас тогтоох хүсэлт мөн гэр бүлийн холбогдолтой хэрэг маргаанд хамаарах эсэх нь эргэлзээтэй байгааг нягтлах;

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн тухайд:

1.Хуулийн төсөл дэх хэл, найруулгын алдааг засах;

2.Орон нутагт Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан шатны тойргийн шүүхэд харьяалах хэрэг, маргааныг шийдвэрлэх шүүх нь шүүхийн тухай хуулийг шинэчлэн боловсруулах хэрэгцээ, шаардлагыг тодорхойлсон “иргэний шүүхэд хандах эрхийн баталгааг бодитой хангах, шүүхийн үйлчилгээг иргэдэд ойртуулж хүртээмжтэй болгох” үндсэн зарчимд нийцсэн эсэхийг дахин судлах;

3.Нийслэл дэх Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан шатны тойргийн шүүхээс бусад буюу орон нутаг дахь Гэр бүл, хүүхдийн хэргийн шүүхийн шүүгчид иргэн, эрүүгийн чиглэлээр мэргэшиж ажиллах ур чадвар, нөхцөл бүрдэх эсэхэд анхаарч шүүхэд итгэх иргэдийн итгэлийг бууруулахгүй байхад анхаарах,

4.Өсвөр насны сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгчөөс сэтгэл зүйчийг оролцуулах зохицуулалттай холбогдон гарах зардал, үр нөлөөг тооцож хуулийн хэрэгжилт үр дүнтэй байхад анхаарах, холбогдох зохицуулалтыг нарийвчлан тусгах.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн тухайд:

1.Зөрчил үйлдсэн өсвөр насны хүний хэргийг нийслэлд Дүүргийн Эрүү, Иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатны тойргийн шүүхээс дахин салгаж Гэр бүл, хүүхдийн хэргийн шүүхэд харьяалуулах нь оновчтой эсэхийг дахин сайтар нягтлах;

2.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зохицуулалт нь уг хуульд нэмэлт оруулах агуулга байх тул хуулийн төслийн нэрийг нэмэлт оруулах байдлаар өөрчлөх.

3.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд зөрчлийн хэргийг Улсын дээд шүүх хяналтын журмаар хянан шийдвэрлэдэггүй тул Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтыг хуульд нийцүүлэн хасах;

4.Хуулийн төслийн 1.8 дугаар зүйлийн 12 дахь хэсэгт тусгасан шүүхийн нэршлийг найруулгын хувьд Шүүх байгуулах тухай хуульд нийцүүлэн томъёолох.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим зүйл, хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн тухайд:

1.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим зүйл, хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн зохицуулалтаас үзэхэд зарим заалт хүчингүй болж байх тул нэрийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим зүйл, хэсэг, **заалтыг** хүчингүй болсонд тооцох тухай гэж нэрлэх;

2.Хуулийн төслийн 6 дугаар зүйлд Гэр бүлийн холбогдолтой хэрэг маргааныг хүсэлтээр үүсэх болон нэхэмжлэлээр үүсэх хэрэг маргаан гэж төрлөөр нь ангилсан байх бөгөөд ийнхүү ялгаж ангилж байгаагийн ач холбогдол, үр дагавар тодорхойгүй байгааг анхаарах;

3. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 135 дугаар зүйлийн 135.2.5-т “осол гэмтэл гарсан эсэх;” 135.2.6-д “хүний ажиллаж байсан байдал;” гэж заасан эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдлыг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар тогтоохоор заасан бөгөөд энэ нь гэр бүлийн холбогдолтой хэрэг маргаанд хамаарахгүй байхад эдгээрийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим зүйл, хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслөөр хүчингүй болгохоор тусгасан нь хуулийн хийдэл, зөрчил үүсгэхээр байгааг засах;

4.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 192 дугаар зүйлд заасан Гэр бүлийн холбогдолтой хэргийн харьяалал гэсэн хэргийг Гэр бүл, хүүхдийн хэргийн шүүх харьяалан шийдвэрлэх эсэх талаар хуулийн төсөлд тусгаагүй орхигдуулсан байна.

---ooOoo---

АШИГЛАСАН МАТЕРИАЛ:

1.Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийн үзэл баримтлал, Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төслүүд, дэлгэрэнгүй танилцуулга

2.Гэр бүл, хүүхдийн холбогдох хэргийг шүүхээс хянан шийдвэрлэх ажиллагааны талаарх хууль тогтоомжид хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан 2024 он

3.Гэр бүл, хүүхдийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны хууль тогтоомжийн харьцуулсан судалгаа. 2024

4.Шүүх байгуулах тухай хууль 2024 он

5.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль 2002 он

6.Гэр бүлийн тухай хууль 1999 он

7. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. 2017 он

8. Зөрчлийн тухай хууль 2017 он

9. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль. 2017 он

10.Хууль тогтоомжийн тухай хууль 2016 он

11. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль. 2002 он

12. Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан аргачлалууд.